



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын
газрын дарга,, Тэргүүлэх
аудитор С.Энхзаяа
Утас:261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261885
Цахим хаяг: boldch@
audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Цэрэнхүү
Утас: 261628
Цахим хаяг: TserenkhuuTs

Монгол Улсын Үндэсний
аудитын газар, Засгийн газрын
IV байр,
УБ – 46, Бага тойруу 6
Цахим хуудас: Audit.mn

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд / САГ-2016/6/СТА-ТТЗ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Онцгой байдлын ерөнхий газар санхүүгийн нэгтгэсэн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 03 дугаар сарын 05-наас 03 дугаар сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн САГ-ын ахлах аудитор Ц.Цэрэнхүү хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 03 дугаар сарын 04-нд ҮАГ-т ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Онцгой байдлын ерөнхий газар нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна .

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Онцгой байдлын ерөнхий газар нь Монгол Улсын хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин, түүх соёлын үнэт зүйлсийг болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, хүч хэрэгслийн

чадавхийг нэмэгдүүлэх замаар Монгол хүний аюулгүй амьдрах таатай нөхцлийг бүрдүүлж, улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд үйл ажиллагааны хүрээнд “Онцгой байдлын албаны тухай”, “Гамшгаас хамгаалах тухай”, “Галын аюулгүй байдлын тухай” хуулиудыг мөрдөж байна.

Тус салбарын гол зорилт нь Онцгой байдлын алба эрхэлсэн байгууллагын албан хаагчдын сахилга бат, ёс зүй, хариуцлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хүч хэрэгслийн бэлэн байдал, чадавхийг бэхжүүлэх асуудал юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд МУ-ын Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.37-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч гэж ТЭЗ-аас хуваарилсан чиг үүргийн төсвыг төлөвлөх, ТШЗ-д хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг хэлнэ” гэж заасны дагуу ОБЕТ-ын дарга ТТЗ-ийн үүрэг гүйцэтгэж байна.

Тус байгууллагын 2015 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгосон байна.

Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 71 төсвийн шууд захирагчийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд 85.9 хувь нь аудитад хамрагдсан байна. Нийт аудитад хамрагдсан байгууллагуудын 97.0 хувьд нь ЯАГ, 3.0 хувьд нь ХАК тус тус аудит хийсэн байна. Аудитаар 61 байгууллага буюу 100 хувьд нь зөрчилгүй санал дүгнэлт өгчээ.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 5 хяналтын горим, 3 нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн түвэгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2 /

Онцгой байдлын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Plastic” програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын 5 хяналтын горим, 3 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Онцгой байдлын ерөнхий газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Материаллаг байдлын түвшинг 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт зардлын 2 хувиар буюу 2,169.2 сая төгрөгөөр тогтоов.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангахад анхаарч, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн захирагч нь 2015 онд урсгал зардалд 53,256.0 сая төгрөг батлагдсанаас 51,695.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1,660.5 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 3 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 5 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Нөөцийн барааны авлагаас эзэн холбогдогч нь тодорхой бус, шүүхийн шийдвэр гарсан авлагуудыг өнөөг хүртэл шийдвэрлээгүй, гадаад, дотоодын их,дээд сургуульд суралцагсдад цалингийн сангаас үндсэн цалинг олгосон, зарим үндсэн хөрөнгийг түүвэрлэн шалгахад дутагдсан, нөөцийн барааны авлага, өглөгийг хууль эрх зүйн хувьд ямар байгууллага барагдуулж байх талаар тодорхой заалт байхгүй зэрэг нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, хуулиудын холбогдох заалт, санхүүгийн тайлангийн оршин байх, хамааралтай байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг

шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

1. ОБЕГ-ын даргын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан нөөцийн барааны авлага дансны ажил гүйлгээний дүнг санхүүгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган шалгахад эзэн холбогдогч нь тодорхой бус 246.3 сая төгрөг, шүүхийн шийдвэр гарсан боловч данснаас хасагдаагүй 734.0 сая төгрөг, нийт 980.3 сая төгрөгийн авлагыг өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Эзэн холбогдогч нь тодорхой бус, шүүхийн шийдвэр гарсан боловч данснаас хасагдаагүй нийт 980.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг ОБЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж, шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

2. ОБЕГ-ын хэмжээнд дотоод, гадаадын их сургуульд суралцаж буй ажиллагсад, Тухайлбал: тайлант онд ОХУ-ын академи, ХСИС-д суралцаж буй нэр бүхий 8 хүнд 52.8 сая төгрөгийн үндсэн цалинг байгууллагын цалингийн зардлаас олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д “Төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэхэд, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах”, МУЗГ-ын 1995 оны 218 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 29-д “Төрийн албан хаагчийг 90 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байсан албан тушаалын цалинг олгоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Цаашид давтан сурах, мэргэжлээ дээшлүүлэхээр сурч буй ажиллагсад үндсэн цалинг олгох, их, дээд сургуульд суралцаж байгаа бол үндсэн цалинг олгохгүй байх талаар зөвлөмж өгөх

3. Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэлээс зарим үндсэн хөрөнгө бодитойгоор оршин байгаа эсэхэд түүвэр хийж, шалгаж үзэхэд 5.5 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг зөөврийн нөтбүүк, 4.8 сая төгрөгийн үнэтэй 4 ширхэг Ай пад гар утас дутагдсан нь санхүүгийн тайлангийн батламж, мэдэгдлийн “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр бодитой оршин байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: НББТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Санхүүгийн тайлан нь үнэн зөв баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэсэн байх” гэсэн заалтыг баримталж, дутагдсан хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын комиссоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, цаашид байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгөд эхний хагас жилд багтаан тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

4. ОБЕГ нь тайлант онд өнгөрсөн оны нөөцийн барааны авлага болох 4,565.2 сая төгрөгийн авлагаас 2,700.7 сая төгрөгийн авлагыг барагдуулсан боловч МУЗГ-ын 2015 оны 154 дүгээр тогтоолоор газар тариалан эрхэлдэг 100 гаруй аж ахуйн нэгжид хаврын тариалалтанд зориулж, улсын нөөцөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 2.7 тэрбум төгрөгийн үрийн улаан буудайг зээлээр олгосон байна. Хур бороо ороогүй, ган гачиг болсны улмаас зээл авсан ААН-үүд ургац алдан, зээлээ хугацаандаа төлж чадаагүйгээс тайлант оны эцэст нөөцийн барааны авлага 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Шийдвэрлэсэн: Цаашид ОБЕГ-ын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр улс орны цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсч байгаа улаан буудайн үрийн эргэлтийн авлага, өр төлбөрийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

5. Тайлант онд салбарын хэмжээгээр өглөг 4,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яамнаас нөөцийн барааны санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс, үрийн улаан буудай, өвс тэжээл нийлүүлсэн байгууллагуудад төлөх 2,7 тэрбум төгрөг, Онцгой байдлын алба эрхэлсэн байгууллагаас 2014-2015 онд цэргийн тэтгэвэрт гарсан 133 албан хаагчдад олгох тэтгэвэр, тэтгэмжийн өглөг 2,2 тэрбум төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн: Санхүүжилтээс шалтгаалан үүссэн өр, авлагыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг алдаа тогтоогдоогүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Онцгой байдлын ерөнхий газрын газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,984.5 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн ба уг зөрчлийг барагдуулах талаар аудиторов зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2014 оны санхүүгийн нэггэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй, 1 албан шаардлага өгсөн ба түүнийг хэрэгжүүлж, биелэлтийг 2015 оны 09 дүгээр сарын 9/2469 дугаар албан бичгээр ҮАГ-т ирүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Авлага

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Цалин

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 1

Үндсэн хөрөнгө

Тэргүүлэх ач холбогдол №4 зүйлс:

Асуудал 1

Авлага

Тэргүүлэх ач холбогдол №5 зүйлс:

Асуудал 1

Өглөг

2010 оны 3 дугаар сарын
01

2015 оны 03 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Онцгой байдлын ерөнхий газарт зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Онцгой байдлын ерөнхий газрын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

ОБЕГ-ын даргын төсвийн 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тусгагдсан нөөцийн барааны авлага дансны ажил гүйлгээний дүнг санхүүгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган шалгахад эзэн холбогдогч нь тодорхой бус 246.3 сая төгрөг, шүүхийн шийдвэр гарсан боловч данснаас хасагдаагүй 734.0 сая төгрөг, нийт 980.3 сая төгрөгийн авлагыг өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Хууль тогтоомжийн заалт зөрчигдөх, санхүүгийн тайлангийн батламж, мэдэгдлийн холбогдох заалт зөрчигдөх

ҮАГ-ын зөвлөмж

Эзэн холбогдогч нь тодорхой бус, шүүхийн шийдвэр гарсан боловч данснаас хасагдаагүй нийт 980.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг ОБЕГ-ын даргын зөвлөлд танилцуулж, шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт:

ОБЕГ-ын хэмжээнд дотоод, гадаадын их сургуульд суралцаж буй ажиллагсдад, Тухайлбал: тайлант онд ОХУ-ын академи, ХСИС-д суралцаж буй нэр бүхий 8 хүнд 52.8 сая төгрөгийн үндсэн цалинг байгууллагын цалингийн зардлаас олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д “Төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэжлээ дээшлүүлэхэд, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах”, МУЗГ-ын 1995 оны 218 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 29-д” Төрийн албан хаагчийг 90 хүртэл хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэжлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байсан албан

Эрсдэлүүд

Хууль, тогтоомжийн заалт зөрчигдөх, оршин байх, иж бүрэн байх гэсэн санхүүгийн батламж мэдэгдэл зөрчигдөх,

ҮАГ-ын зөвлөмж:

Цаашид давтан сурах, мэргэжлээ дээшлүүлэхээр сурч буй ажиллагсдад үндсэн цалинг олгох, их, дээд сургуульд суралцаж байгаа бол үндсэн цалинг олгохгүй байх талаар зөвлөмж өгөх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт:

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэлээс зарим үндсэн хөрөнгө бодитойгоор оршин байгаа эсэхэд түүвэр хийж, шалгаж үзэхэд 5.5 сая төгрөгийн үнэтэй 3 ширхэг зөөврийн нөтбүүк, 4.8 сая төгрөгийн үнэтэй 4 ширхэг Ай пад гар утас дутагдсан нь санхүүгийн тайлангийн батламж, мэдэгдлийн “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө, өр төлбөр бодитой оршин байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж:

НББТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т “Санхүүгийн тайлан нь үнэн зөв баримт материал, бодит тоо мэдээнд үндэслэсэн байх “гэсэн заалтыг баримталж, дутагдсан хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын комиссоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, цаашид байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгөд эхний хагас жилд багтаан тооллого хийж, үр дүнг шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

Эрсдэлүүд

Оршин байх, иж бүрэн байх гэсэн санхүүгийн батламж мэдэгдэл зөрчигдөх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт:

ОБЕГ нь тайлант онд өнгөрсөн оны нөөцийн барааны авлага болох 4,565.2 сая төгрөгийн авлагаас 2,700.7 сая төгрөгийн авлагыг барагдуулсан боловч МУЗГ-ын 2015 оны 154 дүгээр тогтоолоор газар тариалан эрхэлдэг 100 гаруй аж ахуйн нэгжид хаврын тариалалтанд зориулж, улсын нөөцөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 2.7 тэрбум төгрөгийн үрийн улаан буудайг зээлээр олгосон байна. Хур бороо ороогүй, ган гачиг болсны улмаас зээл авсан ААН-үүд ургац алдан, зээлээ хугацаандаа төлж чадаагүйгээс тайлант оны эцэст нөөцийн барааны авлага 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Цаашид ОБЕГ-ын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр улс орны цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсч байгаа улаан буудайн үрийн эргэлтийн авлага, өр төлбөрийн асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

Эрсдэлүүд

Оршин байх, иж бүрэн байх гэсэн санхүүгийн батламж мэдэгдэл зөрчигдөх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт:

Тайлант онд салбарын хэмжээгээр өглөг 4,5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь Сангийн яамнаас нөөцийн барааны санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс, үрийн улаан буудай, өвс тэжээл нийлүүлсэн байгууллагуудад төлөх 2,7 тэрбум төгрөг, Онцгой байдлын алба эрхэлсэн байгууллагаас 2014-2015 онд цэргийн тэтгэвэрт гарсан 133 албан хаагчдад олгох тэтгэвэр, тэтгэмжийн өглөг 2,2 тэрбум төгрөгийн өглөг үүссэнтэй холбоотой байна.

ҮАГ-ын зөвлөмж:

Санхүүжилтээс шалтгаалан үүссэн өр, авлагыг холбогдох байгууллагад нь тавьж шийдвэрлэх талаар зөвлөмж өгөх

Эрсдэлүүд

Оршин байх, иж бүрэн байх гэсэн санхүүгийн батламж мэдэгдэл зөрчигдөх,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Т.БАДРАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.25 № 3/554
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Онцгой байдлын ерөнхий газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын төсвийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2016\0325SAG25.Docx

070541

УХА0122

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,782,139,952.26	94,630,793,876.90
МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,636,356.02	122,491,370.83
Кассанд байгаа бэлэн мөнгө	55,920.00	-
Төгрөг	55,920.00	
Банкинд байгаа бэлэн мөнгө	79,580,436.02	122,491,370.83
Төгрөг	79,580,436.02	122,491,370.83
Арилжааны банк дахь харилцах	647,924.02	20,029.00
Нэмэлт санхүүжилтийн харилцах	78,932,512.00	122,471,341.83
АВЛАГА	4,774,835,631.70	4,184,873,432.72
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,303,721.00	2,677,536.57
Татаас, санхүүжилтийн авлага	117,351,861.85	-
Бусад авлага	4,656,180,048.85	4,182,195,896.15
Байгууллагаас авах авлага	4,488,711,293.85	3,840,204,971.76
Хувь хүмүүсээс авах авлага	167,468,755.00	341,990,924.39
УРЬДЧИЛГАА	109,927,557.47	140,025,861.56
Урьдчилж гарсан зардал	109,927,557.47	140,025,861.56
БАРАА МАТЕРИАЛ	23,864,516,125.73	26,622,991,140.94
Түүхий эд материал	8,963,483,624.91	7,640,912,710.43
Тусгай зориулалттай материал	8,951,718,077.01	7,627,838,788.56
Эм боох материал	11,765,547.90	13,073,921.87
Бэлэн бүтээгдэхүүн	129,599,904.90	227,295,930.80
Хангамжийн материал	14,723,180,695.92	18,702,980,599.71
Бичиг хэргийн материал	88,178,591.88	138,645,596.97
Аж ахуйн материал	2,425,684,247.18	3,360,096,663.77
Сэлбэг хэрэгсэл	591,489,334.22	747,652,552.92
Түлш, шатах тослох материал	90,940,255.75	119,714,050.34
Барилгын засварын материал	15,885,447.96	19,371,489.00

Хүнсний материал	24,481,741.00	13,203,110.28
Бусад хангамжийн материал	11,486,521,077.93	14,304,297,136.43
Мал амьтад	48,251,900.00	51,801,900.00
НӨӨЦИЙН БАРАА	57,953,224,281.34	63,560,412,070.85
Барааны нөөц	26,118,981,582.50	29,283,065,757.87
Үрийн нөөц	6,650,512,347.05	5,221,567,899.97
Тэжээлийн нөөц	3,413,349,981.87	7,356,215,081.59
Шатахууны нөөц	21,770,380,369.92	21,699,563,331.42
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>78,172,897,225.97</u>	<u>100,464,952,473.09</u>
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	78,172,897,225.97	100,464,952,473.09
Биет хөрөнгө	78,165,819,368.47	100,443,077,030.11
Барилга, байгууламж, орон сууц	58,189,301,845.38	64,543,554,907.38
Хуримтлагдсан элэгдэл	(27,910,866,249.98)	(29,357,231,834.55)
Авто-тээврийн хэрэгсэл	33,060,156,141.74	44,486,077,658.52
Хуримтлагдсан элэгдэл	(12,122,761,003.80)	(16,386,666,849.11)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	16,016,187,440.62	28,281,780,793.72
Хуримтлагдсан элэгдэл	(10,589,027,888.11)	(14,059,578,092.88)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,974,011,649.70	2,148,865,605.09
Хуримтлагдсан элэгдэл	(1,168,141,158.06)	(1,306,324,890.66)
Зам, гүүрийн байгууламж	43,646,470.00	42,646,470.00
Хуримтлагдсан элэгдэл	(29,978,142.42)	(30,822,754.94)
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,879,008,022.87	3,432,831,088.37
Хуримтлагдсан элэгдэл	(1,795,078,802.19)	(2,039,313,305.61)
Бусад үндсэн хөрөнгө	1,733,992,481.35	2,402,427,547.35
Хуримтлагдсан элэгдэл	(1,184,762,525.78)	(1,387,478,017.12)
Дуусаагүй барилга, байгууламж	19,070,131,087.15	19,672,308,704.55
Биет бус хөрөнгө	7,077,857.50	21,875,442.98
Програм хангамж	88,442,032.80	95,501,672.16
Хуримтлагдсан элэгдэл	(81,950,269.05)	(73,985,447.93)
Бусад биет бус хөрөнгө	2,379,050.00	2,379,050.00

Хуримтлагдсан элэгдэл	(1,792,956.25)	(2,019,831.25)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>164,955,037,178.23</u>	<u>195,095,746,349.99</u>
НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>806,312,951.98</u>	<u>5,389,632,424.41</u>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	806,312,951.98	5,389,632,424.41
Богино хугацаат үнэт цаас	-	285,468,325.00
Төгрөг	-	285,468,325.00
Бусад үнэт цаас		285,468,325.00
Өглөг	806,312,951.98	5,104,164,099.41
Ажилчидтай холбогдсон өглөг	26,195,361.50	20,139,930.14
Бараа үйлчилгээний зардлын өглөг	254,842,220.00	57,975,736.40
Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	387,587.00	387,587.00
Бусад өглөг	524,887,783.48	5,025,660,845.87
Байгууллагад төлөх өглөг	507,595,979.55	2,734,694,968.79
Хувь хүмүүст төлөх өглөг	17,291,803.93	2,290,965,877.08
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>164,148,724,226.55</u>	<u>189,706,113,925.58</u>
Засгийн газрын хувь оролцоо	164,148,724,226.55	189,706,113,925.58
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	74,815,998,954.01	74,878,337,207.55
Өмч: төрийн	74,815,998,954.01	74,878,337,207.55
Хуримтлагдсан үр дүн	73,376,004,163.92	98,964,487,906.04
Өмнөх үеийн үр дүн	73,376,004,163.92	73,396,867,786.71
Тайлант үеийн үр дүн		25,567,620,119.33
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,956,721,108.62	15,863,288,811.99
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>164,955,037,178.53</u>	<u>195,095,746,349.99</u>

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	121,468,326,647.25	150,201,804,849.02
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	39,453,312,638.80	58,138,875,507.59
Нийтлэг татварын бус орлого	39,453,312,638.80	55,970,160,824.06

Төсөв байгууллагын өөрийн орлого	14,863,791,373.02	55,970,160,824.06
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,543,904,495.52	2,825,947,462.61
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,278,260,003.37	50,711,610.27
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,041,626,874.13	53,093,501,751.18
Бусад орлого	24,589,521,265.78	
Тусламжийн орлого	-	2,168,714,683.53
Хандив тусламж /дотоод/		941,786,392.97
Хандив тусламж /гадаад/		1,226,928,290.56
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	82,015,014,008.45	92,062,929,341.43
Улсын төвлөрсөн төсвөөс	72,298,539,461.00	82,802,738,677.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	53,886,926,002.00	58,332,161,478.00
Хөрөнгийн санхүүжилт	18,411,613,459.00	24,470,577,199.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	8,107,028,746.45	9,260,190,664.43
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,061,999,759.88
ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,181,884,476.00	5,935,825,290.32
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,348,945,613.00	1,684,486,538.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,752,553.04	470,503,197.13
Төсвийн урамшуулал	260,446,104.41	107,375,879.10
Төсвийн захирагчдаас	1,609,445,801.00	-
Хөрөнгийн	1,609,445,801.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	104,840,567,846.11	105,233,153,846.41
УРСГАЛ ЗАРДАЛ	95,922,519,197.73	90,069,120,248.34
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	71,165,257,629.44	74,054,295,016.93
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,031,310,649.26	39,158,166,831.97
Үндсэн цалин	32,608,121,720.28	37,814,937,103.32
Нэмэгдэл	980,080,933.17	29,412,018.00
Унаа хоолны хөнгөлөлт	433,681,179.81	425,627,962.00
Урамшуулал		1,500,000.00
Гэрээт ажлын хөлс	9,426,816.00	886,689,748.65

Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	969,152,379.13	1,161,526,539.93
Тэтгэврийн даатгал	223,788,591.56	289,832,918.41
Тэтгэмжийн даатгал	22,745,806.79	48,331,995.99
ҮОМШӨ-ний даатгал	32,710,809.29	34,943,763.75
Ажилгүйдлийн даатгал	10,080,369.38	8,780,623.41
Эрүүл мэндийн даатгал	679,826,802.11	779,637,238.37
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,151,606,601.65	2,687,725,767.06
Гэрэл, цахилгаан	353,696,633.67	436,399,233.85
Түлш, халаалт	1,297,565,210.88	1,623,822,229.93
Цэвэр, бохир ус	130,821,371.74	143,374,239.32
Байрны түрээс	369,523,385.36	484,130,063.96
Хангамж, бараа материалын зардал	3,101,159,148.38	2,491,786,949.99
Бичиг хэрэг	134,464,928.25	158,717,578.96
Тээвэр, шатахуун	2,100,628,589.34	2,017,053,943.37
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	173,375,810.13	145,430,698.16
Ном, хэвлэл	10,769,017.00	6,676,400.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		7,786,099.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,544,532.00	104,889,849.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	58,076,490.00	-
Бараа материал акталсны зардал	609,299,781.66	51,232,381.50
Нормативт зардал	4,000,740,254.43	2,665,196,260.64
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,977,570.80	34,416,051.15
Хоол, хүнс	689,407,850.00	580,706,654.92
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,264,354,833.63	2,050,073,554.57
Эд хогшил, урсгал засварын зардал	13,300,363,202.92	5,723,274,333.23
Багаж, техник, хэрэгсэл	58,423,667.93	410,233,885.04
Тавилга	175,904.00	43,353,560.20
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	25,926,048.17	4,273,051,955.96
Урсгал засвар	13,215,837,582.82	996,634,932.03
Томилолт, зочны зардал	1,100,955,925.71	1,284,676,133.80

Гадаад албан томилолт	33,806,735.00	23,916,763.20
Дотоод албан томилолт	1,063,616,912.71	1,256,730,990.60
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,532,278.00	4,028,380.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,680,659,335.25	2,412,769,518.28
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	958,898,137.17	1,642,244,324.26
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		17,908,121.38
Даатгалын үйлчилгээ	441,642,793.22	633,903,967.24
Тээврийн хэрэгслийн татвар		26,922,409.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		8,346,725.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		15,199,479.00
Газрын төлбөр	5,900,000.00	68,244,492.40
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	274,218,404.86	
Бараа үйлчилгээний бусад зардал	10,829,310,132.71	16,469,172,682.03
Бараа үйлчилгээний бусад зардал	3,169,965,557.28	6,817,946,492.87
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	401,744,863.38	233,623,822.69
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,250,999,712.05	9,417,602,366.47
Найдваргүй авлагын алдагдал	6,600,000.00	
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,757,261,568.29	16,014,825,231.41
Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,231,800.00	49,485,186.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг		
Засгийн газрын гадаад шилжүүлэг	49,231,800.00	49,485,186.00
Бусад урсгал шилжүүлэг	4,908,124,919.00	4,396,648,604.57
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		2,316,446.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,350,000.00	534,771,746.57
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	1,575,800.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,316,957,096.00	3,815,905,399.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	588,242,023.00	43,655,013.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	408,713,056.52	11,568,691,440.84
Төвлөрүүлэх шилжүүлэг	408,713,056.52	11,568,691,440.84
Хөрөнгийн		

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,592,562,092.91	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	13,592,562,092.91	-
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,798,629,699.86	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,105,219,100.00	
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,693,410,599.86	
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,918,048,648.38	15,164,033,598.07
Дотоод эх үүсвэрээр	8,918,048,648.38	15,164,033,598.07
Их засвар	10,965,980.46	
Бусад хөрөнгө		9,923,884,338.00
Стратегийн нөөц хөрөнгө	8,907,082,667.92	5,240,149,260.07
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	<u>16,627,758,801.14</u>	<u>44,968,651,002.61</u>
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	293,656,607.62	19,401,030,883.28
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	293,656,607.62	19,401,030,883.28
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	<u>16,334,102,193.52</u>	<u>25,567,620,119.33</u>

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	<u>86,059,501,060.84</u>	<u>95,169,347,575.29</u>
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,986,511,882.18	2,861,767,188.28
Нийтлэг татварын бус орлого	9,986,511,882.18	2,861,767,188.28
Төсөв байгууллагын өөрийн орлого	9,986,511,882.18	2,861,767,188.28
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,820,087,885.14	2,802,218,104.98
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	166,423,997.04	59,549,083.30
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	76,072,989,178.66	92,307,580,387.01
Улсын төвлөрсөн төсвөөс	71,183,956,211.00	82,802,738,677.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	53,886,926,002.00	58,332,161,478.00
Хөрөнгийн санхүүжилт	18,411,613,459.00	24,470,577,199.00
Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	(1,114,583,250.00)	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,889,032,967.66	9,504,841,710.01

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		1,099,911,356.88
ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,184,051,786.56	5,935,825,290.32
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,683,131,353.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	444,535,076.69	669,197,830.71
Төсвийн урамшуулал	260,446,104.41	116,775,879.10
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	57,060,606,296.89	82,311,011,086.48
УРСГАЛ ЗАРДАЛ	57,060,606,296.89	82,311,011,086.48
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	48,513,717,120.52	57,934,579,512.07
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,080,408,639.03	39,004,450,018.93
Үндсэн цалин	32,672,848,018.43	37,496,282,934.10
Нэмэгдэл	972,626,023.60	
Унаа хоолны хөнгөлөлт	434,934,597.00	468,467,691.06
Гэрээт ажлын хөлс		1,039,699,393.77
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	956,074,284.83	1,144,345,081.77
Тэтгэврийн даатгал	218,922,795.25	291,368,199.59
Тэтгэмжийн даатгал	21,545,445.18	45,548,208.88
ҮОМШӨ-ний даатгал	30,665,226.70	32,864,889.07
Ажилгүйдлийн даатгал	11,605,530.10	10,068,352.49
Эрүүл мэндийн даатгал	673,335,287.60	764,495,431.74
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,198,007,543.62	2,120,462,560.88
Гэрэл, цахилгаан	352,714,773.67	428,871,076.77
Түлш, халаалт	1,273,196,193.66	1,460,902,472.28
Цэвэр, бохир ус	128,615,787.74	130,232,482.46
Байрны түрээс	443,480,788.55	100,456,529.37
Хангамж, бараа материалын зардал	2,123,122,285.65	2,253,404,916.81
Бичиг хэрэг	86,558,634.63	83,615,718.51
Тээвэр, шатахуун	1,822,782,185.99	1,916,771,262.98
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	174,684,341.03	127,263,619.32
Ном, хэвлэл	15,502,567.00	12,417,320.00

Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		8,232,700.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,594,557.00	105,104,296.00
Нормативт зардал	2,544,571,637.00	3,542,718,728.40
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,275,592.00	44,878,477.00
Хоол, хүнс	639,767,908.00	525,750,951.40
Нормын хувцас, зөөлөн эдтэл	1,885,528,137.00	2,972,089,300.00
Эд хогшил, урсгал засварын зардал	397,144,233.00	464,415,709.62
Багаж, техник, хэрэгсэл	55,940,230.00	68,795,155.90
Тавилга		248,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,549,790.00	15,655,720.00
Урсгал засвар	327,654,213.00	379,716,833.72
Томилолт, зочны зардал	256,348,394.70	1,287,807,905.20
Гадаад албан томилолт	33,806,735.00	23,916,763.20
Дотоод албан томилолт	219,290,779.70	1,260,150,562.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,250,880.00	3,740,580.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,266,569,801.80	2,895,535,829.26
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,785,506,205.80	2,099,454,639.86
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		22,998,942.00
Даатгалын үйлчилгээ	475,163,596.00	652,370,004.00
Тээврийн хэрэгслийн татвар		27,331,519.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо		10,208,225.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ		17,744,149.00
Газрын төлбөр	5,900,000.00	65,309,950.40
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		118,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал	3,691,470,300.89	5,221,438,761.20
Бараа үйлчилгээний бусад зардал	3,251,950,041.68	4,924,173,929.20
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	439,520,259.21	297,264,832.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,546,889,176.37	24,376,431,574.41
Засгийн газрын урсгал шилжүүлэг	49,231,800.00	49,485,186.00
Засгийн газрын гадаад шилжүүлэг	49,231,800.00	49,485,186.00

Бусад урсгал шилжүүлэг	3,299,132,525.14	2,341,606,950.57
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,350,000.00	585,030,250.57
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	1,575,800.00	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,871,906,343.00	1,756,076,700.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	424,300,382.14	500,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	408,713,056.52	13,060,077,665.43
Төвлөрүүлэх шилжүүлэг	408,713,056.52	2,859,569,442.43
Хөрөнгийн		10,200,508,223.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	44,209,490.00
Хөрөнгийн		44,209,490.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,789,811,794.71	8,881,052,282.41
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,789,811,794.71	8,676,930,325.41
Хөрөнгийн		204,121,957.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<u>28,998,894,763.95</u>	<u>12,858,336,488.81</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	31,315,838,385.30	12,815,481,474.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	31,315,838,385.30	12,815,481,474.00
Дотоод эх үүсвэрээр	31,315,838,385.30	12,815,481,474.00
Тоног төхөөрөмж	7,781,188,530.00	
Стратегийн нөөц хөрөнгө	11,812,489,316.30	6,692,309,393.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,722,160,539.00	6,123,172,081.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<u>(31,315,838,385.30)</u>	<u>(12,815,481,474.00)</u>
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,114,583,250.00	-
Эргэж төлөгдөх зээл	1,114,583,250.00	
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,114,583,250.00	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,202,360,371.35)	42,855,014.81
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,281,996,727.37	79,636,356.02
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,636,356.02	122,491,370.83

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,815,998,954.01	15,956,721,108.62	57,041,901,970.40		147,814,622,033.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,815,998,954.01	15,956,721,108.62	57,041,901,970.40	-	147,814,622,033.03
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
7	Тайлант үеийн үр дүн			16,334,102,193.52		16,334,102,193.52
8	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,815,998,954.01	15,956,721,108.62	73,376,004,163.92	-	164,148,724,226.55
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			20,863,622.79		20,863,622.79
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	74,815,998,954.01	15,956,721,108.62	73,396,867,786.71	-	164,169,587,849.34
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	62,338,253.54				62,338,253.54
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(93,432,296.63)			(93,432,296.63)
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
15	Тайлант үеийн үр дүн			25,567,620,119.33		25,567,620,119.33
16	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	74,878,337,207.55	15,863,288,811.99	98,964,487,906.04	-	189,706,113,925.58

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

ЭЗ Ангилал 2015	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		53,920.00	53,920.00	#DIV/0!
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	91,198,671,800.00	74,189,231,724.73	(17,009,440,075.27)	-18.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	73,255,929,600.00	62,992,624,270.73	(10,263,305,329.27)	-14.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,845,812,700.00	49,369,979,431.73	(1,475,833,268.27)	-2.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	38,952,973,000.00	38,733,630,459.31	(219,342,540.69)	-0.56
210101	Үндсэн цалин	37,458,306,000.00	37,240,074,536.48	(218,231,463.52)	-0.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	490,118,000.00	468,467,691.06	(21,650,308.94)	-4.42
210105	Гэрээт ажлын хөлс	1,004,549,000.00	1,025,088,231.77	20,539,231.77	2.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,451,010,200.00	1,119,351,617.34	(331,658,582.66)	-22.86
210201	Тэтгэврийн даатгал	432,553,279.00	289,993,136.83	(142,560,142.17)	-32.96
210202	Тэтгэмжийн даатгал	44,751,693.00	21,982,997.77	(22,768,695.23)	-50.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	62,641,745.19	32,839,560.23	(29,802,184.96)	-47.58
210204	Ажилгүйдлийн даатгал	15,415,121.81	10,065,819.61	(5,349,302.20)	-34.70
210205	Эрүүл мэндийн даатгал	895,648,361.00	764,470,102.90	(131,178,258.10)	-14.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,655,108,100.00	2,111,695,055.88	(543,413,044.12)	-20.47
210301	Гэрэл, цахилгаан	481,793,000.00	423,484,855.77	(58,308,144.23)	-12.10
210302	Түлш, халаалт	1,545,110,600.00	1,459,459,014.28	(85,651,585.72)	-5.54
210303	Цэвэр, бохир ус	143,664,500.00	128,294,656.46	(15,369,843.54)	-10.70
210304	Байрны түрээс	484,540,000.00	100,456,529.37	(384,083,470.63)	-79.27
2104	Хангамж, бараа материалын зардал	1,986,693,300.00	1,914,416,067.54	(72,277,232.46)	-3.64
210401	Бичиг хэрэг	53,408,100.00	57,226,292.00	3,818,192.00	7.15
210402	Тээвэр, шатахуун	1,703,344,700.00	1,627,102,168.37	(76,242,531.63)	-4.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	114,403,800.00	107,630,247.17	(6,773,552.83)	-5.92
210404	Ном, хэвлэл	12,300,000.00	12,417,320.00	117,320.00	0.95
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,292,100.00	7,432,700.00	(859,400.00)	-10.36
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	94,944,600.00	102,607,340.00	7,662,740.00	8.07

2105	Нормативт зардал	3,488,758,000.00	3,447,604,789.40	(41,153,210.60)	-1.18
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,861,400.00	19,546,714.00	2,685,314.00	15.93
210502	Хоол, хүнс	487,744,300.00	455,968,775.40	(31,775,524.60)	-6.51
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,984,152,300.00	2,972,089,300.00	(12,063,000.00)	-0.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	247,842,800.00	243,401,305.00	(4,441,495.00)	-1.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	67,470,200.00	62,754,417.00	(4,715,783.00)	-6.99
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	30,377,900.00	19,835,720.00	(10,542,180.00)	-34.70
210604	Урсгал засвар	149,994,700.00	160,811,168.00	10,816,468.00	7.21
2107	Томилолт, зочны зардал	85,961,500.00	65,906,425.00	(20,055,075.00)	-23.33
210701	Гадаад албан томилолт	4,392,500.00	6,245,843.00	1,853,343.00	42.19
210702	Дотоод албан томилолт	75,880,800.00	55,920,002.00	(19,960,798.00)	-26.31
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,688,200.00	3,740,580.00	(1,947,620.00)	-34.24
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,448,320,500.00	1,297,004,986.26	(151,315,513.74)	-10.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	574,525,500.00	502,089,796.86	(72,435,703.14)	-12.61
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	40,725,700.00	22,998,942.00	(17,726,758.00)	-43.53
210803	Даатгалын үйлчилгээ	674,549,000.00	651,464,004.00	(23,084,996.00)	-3.42
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,667,900.00	27,331,519.00	(7,336,381.00)	-21.16
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,728,400.00	10,208,225.00	(4,520,175.00)	-30.69
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	24,137,400.00	17,484,149.00	(6,653,251.00)	-27.56
210807	Газрын төлбөр	84,833,200.00	65,309,950.40	(19,523,249.60)	-23.01
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	153,400.00	118,400.00	(35,000.00)	-22.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	529,145,300.00	436,968,726.00	(92,176,574.00)	-17.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	226,601,400.00	171,689,794.00	(54,911,606.00)	-24.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	302,543,900.00	265,278,932.00	(37,264,968.00)	-12.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,410,116,900.00	13,622,644,839.00	(8,787,472,061.00)	-39.21
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	20,049,500,000.00	11,346,549,324.00	(8,702,950,676.00)	-43.41
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	20,000,000,000.00	11,297,064,138.00	(8,702,935,862.00)	-43.51
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	49,500,000.00	49,485,186.00	(14,814.00)	-0.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,360,616,900.00	2,276,095,515.00	(84,521,385.00)	-3.58
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	604,334,000.00	520,018,815.00	(84,315,185.00)	-13.95

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	206,200.00		(206,200.00)	-100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,756,076,700.00	1,756,076,700.00	-	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,942,742,200.00	11,196,607,454.00	(6,746,134,746.00)	-37.60
220001	Барилга байгууламж	5,513,000,000.00	4,504,298,061.00	(1,008,701,939.00)	-18.30
224001	Стратегийн нөөц хөрөнгө	12,429,742,200.00	6,692,309,393.00	(5,737,432,807.00)	-46.16
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	91,198,671,800.00	74,189,177,804.73	(17,009,493,995.27)	-18.65
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	86,561,191,700.00	73,078,524,516.73	(13,482,667,183.27)	-15.58
310001	Улсын төсвөөс санхүүжих	86,561,191,700.00	73,078,524,516.73	(13,482,667,183.27)	-15.58
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,637,480,100.00	1,110,653,288.00	(3,526,826,812.00)	-76.05
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,637,480,100.00	1,108,893,798.00	(3,528,586,302.00)	-76.09
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		1,759,490.00	1,759,490.00	#DIV/0!
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,938.00	3,513.00	(425.00)	-10.79
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	0.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,937.00	3,512.00	(425.00)	-10.80
620001	Удирдах ажилтан	74.00	71.00	(3.00)	-4.05
620002	Гүйцэтгэх ажилтан	3,446.00	3,070.00	(376.00)	-10.91
620003	Үйлчлэх ажилтан	203.00	194.00	(9.00)	-4.43
620004	Гэрээт ажилтан	214.00	177.00	(37.00)	-17.29